УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР
1959
ОНООС
УЛААНБААТАР ХОТ

БАЙГУУЛЛАГЫН СТАНДАРТ

Ус сувгийн удирдах газрын ажиллагсдын ажлын тусгай хувцсанд тавих ерөнхий шаардлага

Албан хэвлэл

CS 11-0605:2025

БҮРТГЭВ.
2025.09.22-2027.09.22
гарын үсэг 20 оны сарын
өдрөөс хүчинтэй

Ус сувгийн удирдах газар
Улаанбаатар хот
2025 он

CS 11-0605:2025

БАТЛАВ:

Ус сувгийн удирдах газрын дарга……/Ц.Төрхүү /

БОЛОВСРУУЛСАН:

ШУТИС-ийн ХСТ-ийн захирал ……/М.Баяр/

Эрдэм шинжилгээний ажилтан ……/Л. Наранцэцэг/

ШҮҮЛТ ХИЙСЭН:

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН

Ахлах мэргэжилтэн……/Ч.Пүрэвдулам/

Өмнөх үг

Энэхүү стандарт нь Ус сувгийн удирдах газрын ажлын тусгай хувцасны стандарт бөгөөд ажлын байран дээр өмсөх хувцсанд тавих бүхий л шаардлагыг тусгасан болно.

Энэхүү стандартыг Монгол Улсын Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль (ШУТИС)-ийн Хувцас судлалын төвийн судлаачид боловсруулан, Ус сувгийн удирдах газрын Хууль эрх зүй, хөдөлмөрийн аюулгүй байдлын хэлтэс бусад алба, нэгж хэсэгт холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын шаардлагуудад нийцүүлэн хянасан.

Хаяг: Улаанбаатар хот,
Баянзүрх дүүрэг, 3-р хороо
Токиогийн гудамж-5,
Ус сувгийн удирдах газар
E-mail: http://www.eus.mn

©УСУГ, 2025

Энэхүү стандарт нь "Ус сувгийн удирдах газар"-ын өмч бөгөөд байгууллагын бичгэр олгосон зөвшөөрөлгүйгээр бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хуулбарлах болон бусад байдлаар ил болгох, тараахыг хориглоно.

БАЙГУУЛЛАГЫН СТАНДАРТ 2025.09.22-2027.09.22

Ангилалтын код: 61.020

Ус сувгийн удирдах газрын ажиллагсдын ажлын тусгай хувцсанд тавих ерөнхий шаардлага	**CS 11-0605:2025**
general requirements for protective workwear of the water supply and sewerage authority	

Ус сувгийн удирдах газрын даргын 2025 оны 09 дугаар сарын 26 -ны өдрийн А/245 тоот тушаалаар батлав.

Энэхүү стандартыг 2026 оны 01 дугаар сарын 02-ны/ний өдрөөс эхлэн заавал мөрдөнө.

Тодорхойлолт

Энэхүү "Ажлын тусгай хувцсанд тавих ерөнхий шаардлага" стандарт нь Ус сувгийн удирдах газрын ажилтнуудын ашиглах ажлын тусгай хувцсанд тавих шаардлагуудыг тогтооно.

1. Зорилго

Өдөр тутам өмсөх ажлын тусгай хувцас нь үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлийн үйлчлэлийг багасгах, урьдчилан сэргийлэх, хамгаалах, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн шаардлагыг хангасан байна.

2. Хамрах хүрээ ба хэрэглэх хүрээ

2.1 Энэхүү стандарт нь Ус сувгийн удирдах газрын ажилтнуудын ашиглах өдөр тутам өмсөх ажлын тусгай хувцсанд тавих шаардлагуудыг тогтоох бөгөөд эдгээрээр хангах ажиллагааг зохион байгуулахад оролцож байгаа ажилтнуудад хамаарна.

2.2 Энэ стандартын норматив шаардлагыг Ус сувгийн удирдах газарт мөрдлөг болгох бөгөөд үндэсэн болон гэрээт ажилтнуудад хамааралтай. Энэхүү стандартад нийцээгүй өдөр тутам өмсөх ажлын тусгай хувцас худалдан авах, олгох, ашиглахад хамаарахгүй.

2.3 Ус сувгийн удирдах газрын тушаал, шийдвэр, зохион байгуулалтын болон байгууллагын норматив баримт бичгүүд нь энэхүү стандарттай нийцсэн байна.

3. Норматив эшлэл

Энэхүү стандартад дараах эш татсан стандарт, баримт бичгүүдийг хэрэглэсэн бөгөөд эш татсан стандартуудад өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны эх материалыг ашиглана. Үүнд:

MNS 1835-2, *Нэхмэл бүтээгдэхүүн. 1м²-ийн жин тодорхойлох,*
MNS 1835-3, *Нэхмэл бүтээгдэхүүн. Зузаан тодорхойлох арга,*
MNS 1835-4, *Нэхмэл бүтээгдэхүүн. Нэхээсний нягт тодорхойлох арга,*
MNS 1835-5, *Нэхмэл бүтээгдэхүүн. Тасрах үеийн даац, суналт тодорхойлох арга,*
MNS 1835-6, *Нэхмэл бүтээгдэхүүн. Усны үйлчлэл тэсвэрлэлт тодорхойлох арга,*
MNS 1836-7, *Нэхмэл бүтээгдэхүүн. Бүрзийлт тодорхойлох арга,*
MNS 1835-8, *Нэхмэл бүтээгдэхүүн. Норгосны дараах хэмжээний өөрчлөлт тодорхойлох арга,*
MNS 1835-9, *Нэхмэл бүтээгдэхүүн.Чийглэг тодорхойлох арга,*
MNS 4535, *Нэхмэл бүтээгдэхүүн. Агаар нэвтрүүлэлт тодорхойлох арга,*

MNS ISO 14184-1, *Нэхмэл бүтээгдэхүүн. Формальдегид тодорхойлох усан экстракцын арга, 1-р хэсэг. Чөлөөт, гидролизод орсон формальдегид*
MNS 4010, *Нэхмэл бүтээгдэхүүн. Ширхэгтийн бүрэлдэхүүн тодорхойлох арга.*
MNS ISO 105-E01, Нэхмэл бүтээгдэхүүн. Будгийн тогтворыг тодорхойлох арга. E01-р хэсэг. Будгийн тогтворыг усанд тодорхойлох,
MNS ISO 105-E04, *Нэхмэл бүтээгдэхүүн. Будгийн тогтворыг хөлсөнд тодорхойлох арга.* E04-р хэсэг. Будгийн тогтворыг хөлсөнд тодорхойлох,
MNS ISO 105-X12, *Нэхмэл бүтээгдэхүүн. Будгийн тогтворыг үрэлтэнд тодорхойлох арга, X12-р хэсэг. Будгийн тогтворыг үрэлтэд тодорхойлох,*
MNS ISO 105-C10, *Нэхмэл бүтээгдэхүүн. Будгийн тогтворыг угаалганд тодорхойлох арга, C10-р бүлэг. Будгийн тогтворыг савангийн эсвэл саван, содын угаалганд тодорхойлох*
MNS ISO 105-D01, *Нэхмэл бүтээгдэхүүн. Будгийн тогтворыг тодорхойлох арга. D01–р хэсэг Перхлор этиленийг хэрэглэн хуурай цэвэрлэгээнд будгийн тогтворыг тодорхойлох,*
MNS ISO 105-X11, *Нэхмэл бүтээгдэхүүн. Будгийн тогтворыг индүүдлэгэнд тодорхойлох арга, X11-р хэсэг, Будгийн тогтворыг индүүдлэгэд тодорхойлох,*
ISO 5077, *Нэхмэл бүтээгдэхүүн – Угаалга, хатаалтын үеийн хэмжээний тогтворжилт тодорхойлох,*
MNS ISO 13688, *Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, Хамгаалалтын хувцас . Ерөнхий шаардлага;*
MNS 4931, *Хөдөлмөрийн хамгаалах хэрэгсэл. Ерөнхий шаардлага, ангилал*
MNS 6295, *Нэхмэл, сүлжмэл, оёмол бүтээгдэхүүний аюулгүй байдлын нийтлэг шаардлага;*
MNS 6306, *Тусгай зориулалтын дулаан хувцас. Ерөнхий шаардлага.*
MNS 4968, *Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ерөнхий шаардлага;*
MNS ISO 4916, *Оёдлын нэр төрөл.Ангилал ба нэр томьёо;*
MNS ISO 4915, *Хатгацын төрөл. Ангилал ба нэр томьёо;*
MNS 3631, *Насанд хүрэгсдийн биеийн хэв шинжит галбирын ангилал, хувцас зохион бүтээлтэнд шаардагдах хэмжээ;*
ISO 3635, *Хувцасны хэмжээг тодорхойлох -Биеийг хэмжих аргууд;*
ISO 8559, *Хувцасны зохион бүтээлт ба антропометрийн судалгаа - Биеийн хэмжээ*
ISO/TR 10652: *Хувцасны стандарт хэмжээг тодорхойлох систем;*
ISO 8559-1, *Биеийн хэмжилтийн антропометрийн тодорхойлолт;*
ISO 8559-2, *Анхдагч ба хоёрдогч хэмжээсийн үзүүлэлтүүд;*
ISO 8559-3, *Биеийн хэмжилтийн хүснэгт, интервал үүсгэх аргачлал;*
ISO 8559-4, Part 4:*Биеийн хэмжилтийн хүснэгтийн хамрах харьцааг тодорхойлох;*
ISO 13688, Хамгаалалтын хувцас- Ерөнхий шаардлагууд;
ISO 11079, *Орчны дулааны эргономик - Хувцасны шаардагдах дулаан тусгаарлалт (IREQ) –г хөргөлтийн нөлөөг ашиглах үед хүйтний стрессийг тодорхойлох ба тайлбарлах;*
ISO 3758, *Нэхмэл эдлэл. Шошгон дээрх арчилгааны тэмдэглээг ашиглах код. Шаардлагууд;*
EN 340, *Хамгаалах хувцас. Ерөнхий шаардлагууд;*
BS EN 342, *Хамгаалах хувцас. Хүйтнээс хамгаалах хувцас*

4. Нэр томьёо, тодорхойлолт

Стандартад дараах тодорхойлолт бүхий нэр томъёо ашигласан болно.

4.1 Ус сувгийн удирдах газрын ажилтан

Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу Ус сувгийн удирдах газартай хөдөлмөрийн болон хөлсөөр ажиллах гэрээ байгуулан ажиллаж байгаа ажилтан

4.2
өдөр тутам өмсөх ажлын тусгай хувцас
ажлын байрандаа байгаа ажилтныг хортой болон аюултай үйлдвэрлэлийн хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаалах зориулалт бүхий нэг бүрийн хамгаалах хэрэгсэл

4.3
механик үйлчлэл
ажлын хувцасны материалын дээд давхаргыг гэмтээх (цоорох, зүсэх, үрэх, урагдах, базах) зэрэгт нөлөөлөх ажлын орчны хүчин зүйлс буюу хөдөлмөрийн багаж хэрэгсэл: *хөдөлгөөнт машин механизм, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн хөдөлгөөнт хэсэг; хөдөлж буй бүтээгдэхүүн, хоосон зай, материал; эвдэрсэн (бүрэн бүтэн байдлыг зөрчсөн) бүтэц; шороон чулуулаг ба задгай материал; бэлдэц, багаж, тоног төхөөрөмжийн хурц ирмэг ба гадаргуугийн тэгш бус байдал; холбох хэрэгсэл, байгууламж, тоног төхөөрөмжийн хурц өнцөг; гэх мэт.*

4.4
үйлдвэрлэлийн ерөнхий бохирдол
агаарын тоосжилт, бохир ус, будаг, цавуу, тослог болон бусад бодисуудын үйлчлэлтэй холбоотой үйлдвэрлэлийн орчны хүчин зүйлс

4.5
үйлдвэрлэлийн аюултай хүчин зүйл
ажлын ээлжийн хугацаанд хурц хордлого, үйлдвэрлэлийн осолд хүргэх, хүний эрүүл мэнд, амь насанд аюул учруулах хүчин зүйл;

4.6
үйлдвэрлэлийн хортой хүчин зүйл
хүний эрүүл мэндэд нөлөөлж өвчлүүлэх, сэтгэхүйд өөрчлөлт оруулах, хөдөлмөрлөх чадварыг бууруулах, мэргэжлийн өвчин бий болгох уршиг бүхий үйлдвэрлэлийн хүчин зүйл;

4.7
Пантон (Pantone) код
даавууны өнгөний олон улсын стандартчилсан систем дэх код;

4.8
хэв шинжит галбир
судалгаа, хэмжилтийн үндсэн дээр стандартчилсан хэмжээс бүхий хүний бие;

4.9
зуны хувцас
хавар, намар, зуны дулаан улиралд тасалгааны хувцасны гадуур өмсөх зориулалттай, гадна орчны нөлөөллөөс хамгаалах хувцас /зуны хүрэм, өмд, комбинзон/

4.10
өвлийн хувцас

өвлийн улиралд тасалгааны хувцасны гадуур өмсөх зориулалттай, дулаалгын давхарга бүхий гадна орчны нөлөөллөөс хамгаалах хувцас /хүрэм, өмд, комбинзон/

4.11
лабораторийн хувцас
лабораторийн ариун өрөөнд багаж, тоног төхөөрөмжтэй ажиллах үед өмсөх хувцас

4.12
өдөр тутам өмсөх ажлын хувцсанд тавих шаардлагууд

4.12.1
хамгаалах шаардлага
бүтээгдэхүүний үндсэнзориулалт болох хамгаалах шинж чанарт тавих шаардлага;

4.12.2 эргономикийн шаардлага
хувцас нь хүний биеийн галбирт тохирсон, хөдөлгөөнд саад учруулахгүй, ажлын онцлог, орчин нөхцөлд нийцсэн хийц бүхий бүрдэл хэсгүүдтэй, биед эвтэйхэн байх шаардлага /хувцас өмсөж тайлахад хялбар байх, халаас, товчлоосны оновчтой байрлал, хувцасны жин г.м/;

4.12.3
эдэлгээний шаардлага
нормт хугацаанд эдэлгээг тэсвэрлэх шинж чанар, засварлах боломж, хэлбэр хадгалалт, хими цэвэрлэгээ, угаалга, индүүдлэг даах чадварт тавих шаардлага;

4.12.4
гоо зүйн шаардлага
хувцасны загварын зохиомж, хийцийн шийдэл, хэлбэр, материалын шинж чанар, тэдгээрийн харилцан зохицол, бүтээгдэхүүний гадаад үзэмжид тавих шаардлага;

4.12.5
зориулалтдаа тохирох (функциональ) шаардлага
өдөр тутам өмсөх ажлын хувцасны үндсэн зориулалтанд нийцэх шаардлага;

4.12.6
хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн шаардлага
ажилтны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангахад тавих материалын дулаан хадгалалт, агаар нэвтрүүлэлт, аюулгүй байдлын шаардлага;

4.13
хувцасны давхаргын багц

4.13.1
хувцасны гадар давхарга
гадуур хувцасны хамгийн гадна талд байрлах, хүний биеийг гадаад орчны нөлөөллөөс хамгаалах материал;

4.13.2
дотор давхарга

хувцсыг өмсөж тайлахад хялбар байлгах, хувцасны дотор талаас элэгдэлт, сэмрэлтээс хамгаалах, үндсэн бүрдэл хэсгүүдийн хэлбэр хадгалалт, бүтээгдэхүүний дотор талын үзэмжтэй байдлыг хангах зориулалт бүхий хувцасны хамгийн дотор талын материал;

4.13.3
дулаалгын давхарга
гадар ба дотор давхаргын дунд байрлах хувцасны дулаан хадгалалтыг нэмэгдүүлэх зориулалт бүхий дулаалгын материал;

4.13.4
гэрэл ойлгогч материал
гэрэл ойлгон, цацруулах шинж чанар агуулсан материал. Гэрэл ойлгогч материалд үндсэн материалд тавих шаардлагууд нийцэхгүй;

4.13.5
флис
полиэстер ширхэгтийг дан эсхүл полиуретан ширхэгттэй хольсон утсаар сүлжиж өнгө, дотор талуудыг үсэлсэн сүлжмэл материал

4.14
материалын шинж чанарын үзүүлэлтүүд

4.14.1
ширхэгтийн бүрэлдэхүүн
нэхмэлийн бүрэлдэхүүнд байгаа ширхэгтүүдийн (хөвөн, полиэстр г.м) эзлэх хувь, %;

4.14.2
гадаргуугийн нягт
нэгж талбайд ноогдох нэхмэлийн сорьцын жинг 1м^2 талбайд шилжүүлж тооцсон жин, г/м^2 ;

4.14.3
тасралтын даац
нэхмэлийн сорьцыг тасрах хүртэл зарцуулагдсан хүчний дээд хэмжээ, Н;

4.14.4
угаасны дараах агшилт
нэхмэлийг угаасны дараах уртын (суурь утасны дагуух) болон өргөний (хөндлөн утасны дагуух) өөрчлөлт, %;

4.14.5
элэгдэл тэсвэрлэлт
нэхмэлийг зориулалтын төхөөрөмжөөр эргэлдэх хөдөлгөөнөөр үрэхэд бөх бат байдлаа хадгалах чанар, эргэлт;

4.14.6
агаар нэвтрүүлэлт
нэгж хугацаанд нэгж талбайгаар нэвтрэн өнгөрөх агаарын урсгалын хэмжээ, дм^3/м^2 с;
4.14.7
формальдегидын агууламж

нэхмэлийн усан экстрактын орчны хүчил шүлтийн тэнцвэрт (ph=4,8-7,5) нөхцөлд байж болох формальдегидын хэмжээ, мг/ кг;

4.14.8
будгийн тогтвор
нэхмэлийн будгийн хөлс, үрэлт, ус, угаалга, индүүдлэг, хими цэвэрлэгээнд тогтвортой байх байдал, балл

4.17
цэвэрлэгээ
бохирдлыг арилгах замаар хувцсыг эрүүл ахуйн талаас ашиглахад тохиромжтой байдалтай болгодог үйл явц.

ЖИЧ: угаалга+ хатаалга, хуурай цэвэрлэгээ + индүүдлэг (эсвэл шаадлагатай бол өөр боловсруулалт) нь цэвэрлэгээний цикл гэж тооцогдоно.

5. Өдөр тутам өмсөх ажлын хувцсанд тавих ерөнхий шаардлага

5.1 Ерөнхий шаардлага

a) Өдөр тутам өмсөх ажлын тусгай хувцас нь үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлийн үйлчлэлийг багасгах, урьдчилан сэргийлэх, хамгаалах, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангасан байна.

b) Өдөр тутам өмсөх ажлын тусгай хувцас нь:
- үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлийн шалтгаан, эх үүсвэр болохгүй
- хүний эрүүл мэндэд хортой нөлөө үзүүлэхгүй,
- хүний биед хүрэлцэх хэсгүүд арьсанд аливаа цочроо, шархлаа үүсгэх хурц ирмэггүй, хатуу ширүүн гадаргуугүй,
- хүний биеийн цусны эргэлт, амьсгал боогдуулахгүй, хөдөлгөөнд саад учруулахгүй,хэтэрхий том эсвэл хүнд биш,
- угаалга, химийн цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн явцад үндсэн шинж чанарууд нь өөрчлөгдөхгүй байна.

c) Өдөр тутам өмсөх ажлын тусгай хувцасны тэмдэглэгээ, тусгай тэмдэглэгээ нь MNS ISO 13688:2000 стандартын болон тодорхой нэр төрлийн хэрэгслийн тэмдэглэгээний шаардлагуудыг хангасан байна.

d) Өдөр тутам өмсөх ажлын тусгай хувцас нь зориулалт, эдэлгээний хугацааг заасан, ашиглах, арчилах, хадгалах заавартай байна.

e) Өдөр тутам өмсөх ажлын тусгай хувцсыг ариун цэвэр, халдвар хамгааллын дүрэм, журам, зааврын дагуу халдваргүйжүүлэх, угаах, ариутгах, гадагш халдвар тархахаас сэргийлнэ.

f) Нэг удаагийн ажлын тусгай хувцсыг дахин угааж хэрэглэхгүй.

g) Өдөр тутам өмсөх ажлын тусгай хувцсыг хүрээлэн буй орчинд хор нөлөөгүйгээр устгана.

5.2 Өдөр тутам өмсөх ажлын хувцасны ангилал

5.2.1 Ус сувгийн удирдах газрын хэмжээнд 5.1-р хүснэгтэд заасан үндсэн нэр төрлийн өдөр тутам өмсөх ажлын хувцсуудыг ашиглана. Эдгээр тусгай хувцасны гадаад байдал нь Ус сувгийн удирдах газрын даргын тушаалаар батлагдсан зургийн

цомогт үзүүлсэн нэгдсэн загвар, дизайнаар боловсруулсан техникийн зургуудтай тохирч байна.

Энэхүү стандартад заагдаж буй ажлын хувцсыг ажил, мэргэжлээс нь хамааруулан дараах байдлаар ангилна.

5.1-р хүснэгт. Ус сувгийн удирдах газрын ажилтны өдөр тутам өмсөх ажлын хувцасны ангилал, ажил мэргэжлээр

№	Нэр төрөл	Ажлын төрөл/ Хувцасны нэр төрөл							
		Инженер, техникийн ажилтнууд	Ажилчид	Лабораторийн ажилчид	Ус түгээгч	Жолооч	Үйлчлэгч	Тогооч	Зохион байгуулагч, харуул хамгаалалтын ажилтан
1	Хувцас	– Зуны хүрэм, өмд – Өвлийн хүрэм, өмд, салдаг хантаазтай – Зуны нимгэн цамц – Хантааз – Хантааз цацруулагчтай	– Зуны хүрэм, өмд – Өвлийн хүрэм, өмд, салдаг хантаазтай – Комбинзон – Комбинзон нэг удаагийн – Гагнуурын тусгай хувцас – Хантааз цацруулагчтай	– Богино ханцуйтай, захгүй цамц, өмд – Өвлийн хүрэм, өмд	– Богино ханцуйтай, захтай цамц \поло\, өмд – Дулаан флис цамц – Өвлийн хүрэм, өмд,	– Зуны хүрэм, өмд – Өвлийн хүрэм, өмд, – Хантааз – Комбинзон – Гагнуурын тусгай хувцас	– Богино ханцуйтай, захтай цамц \поло\, өмд – Дулаан флис цамц – Өвлийн хүрэм, өмд	– Тогооч ийн иж бүрдэл хувцас	– Жакет платье – Цамц өмд
2	Гутал	– Өвлийн ажлын түрийтэй гутал – Зуны ажлын түрийтэй гутал	– Өвлийн ажлын түрийтэй гутал – Зуны ажлын түрийтэй гутал – Усны гутал – Мөрөвчтэй өмдтэй усны гутал	– Лабораторийн гутал – Өвлийн богино түрийтэй гутал – Зуны хамгаалалттай пүүз	– Өвлийн богино түрийтэй гутал	– Өвлийн ажлын түрийтэй гутал – Зуны ажлын түрийтэй гутал – Усны гутал – Мөрөвчтэй өмдтэй усны гутал	–	– Тогооч ийн ажлын гутал	–

ТАЙЛБАР: Ажлын хувцсыг ажилтны ажлын байрны төрөл, ажил үүргийн онцлог, алба цехээс хамааруулж эдэлгээний нормын журмын дагуу хугацаанд нь олгоно.

6. Өдөр тутам өмсөх ажлын хувцсанд тавих техникийн шаардлага
6.1 Өдөр тутам өмсөх ажлын хувцсанд тавих техникийн шаардлагууд

6.1.1 Өмсгөл хэмжээ

Өдөр тутам өмсөх ажлын хувцасны өмсгөл хэмжээ нь ажилтны биеийн хэмжээнд таарсан байна. Хувцасны өмсгөл хэмжээг биеийн өндөр, цээжний 3-р бүслүүр гэсэн үндсэн хэмжээсүүдээр тодорхойлно. Шаардлагатай бол нэмэлтээр дүүргэвчийн хэмжээ (бүсэлхийн бүслүүр- эрэгтэй хүнд), өгзөгний бүслүүр-эмэгтэй хүнд), ханцуйны уртын хэмжээг ашиглана.

Эрэгтэй ажилтны өвлийн болон дулаан улирлын тусгай хувцсыг найман төрлийн өмсгөл хэмжээтэйгээр гурав хүртэл чацтайгаар, эмэгтэй ажилтны өвлийн болон дулаан улирлын тусгай хувцсыг зургаан төрлийн өмсгөл хэмжээтэйгээр гурван өөр чацтайгаар үйлдвэрлэнэ.

Ус сувгийн удирдах газрын ажилтны хувцасны өмсгөл хэмжээ нь 6.1...6.5, гутлын өмсгөл хэмжээ 6.6-р хүснэгтэд үзүүлсэн хэв шинжит галбирын чац, цээжний бүслүүрийн хэмжээнд тохирсон байна. Хэмжээ илэрхийлэх зургийг А хавсралтад үзүүлэв.

6.1-р хүснэгт. Гадуур хувцасны өмсгөл хэмжээ ба биеийн хэмжээ

Хувцасны өмсгөл хэмжээ	Хэв шинжит галбирын чац,см (хэлбэлзэл 6 см)	Чацын хэмжээний хэлбэлзэл, см	Хэв шинжит галбирын цээжний бүслүүр, см (хэлбэлзэл 4 см)	Цээжний бүслүүрийн хэмжээний хэлбэлзэл, см
Эрэгтэй				
44	164 170	161-167 167-173	88	86-90
46	164 170 176 182	161-167 167-173 173-179 179-185	92	90-94
48	164 170 176 182 188	161-167 167-173 173-179 179-185 185-191	96	94-98
50	164 170 176 182 188	161-167 167-173 173-179 179-185 185-191	100	98-102
52	164 170 176 182 188	161-167 167-173 173-179 179-185 185-191	104	102-106
54	164 170 176 182 188	161-167 167-173 173-179 179-185 185-191	108	106-110
56	164 170 176 182	161-167 167-173 173-179 179-185	112	110-114

	188	185-191		
58	164 170 176 182 188	161-167 167-173 173-179 179-185 185-191	116	114-118
60	164 170 176 182 188	161-167 167-173 173-179 179-185 185-191	120	118-122
Эмэгтэй				
42	158 164 170 176	155-161 161-167 167-173 173-179	84	82-86
44	158 164 170 176	155-161 161-167 167-173 173-179	88	86-90
46	158 164 170 176	155-161 161-167 167-173 173-179	92	90-94
48	158 164 170 176	155-161 161-167 167-173 173-179	96	94-98
50	158 164 170 176	155-161 161-167 167-173 173-179	100	98-102
52	158 164 170 176	155-161 161-167 167-173 173-179	104	102-106

ТАЙЛБАР: * хэмжээ нь ялгаатай буюу онцлог хэмжээний ангилалд багтах тул үйлдвэрлэх үед захиалагч тусгайлсан захиалга үүсгэнэ.

6.2-р хүснэгт. Ажлын цамцны өмсгөл хэмжээ ба биеийн хэмжээ

Эрэгтэй					
Цамцны өмсгөл хэмжээ	Хүзүүний бүслүүр, см (хэлбэлзэл 1 см)	Хүзүүний бүслүүрийн хэлбэлзэл, см	Гарын урт, см	Цээжний бүслүүр, см (хэлбэлзэл 4 см)	Цээжний бүслүүрийн хэлбэлзэл, см
37	37	36,5-37,5	58 62	88	86-90
38	38	37,5-38,5	58 62	88	86-90
39	39	38,5-39,5	58 63	92	90-94
40	40	39,5-40,5	59 63	96	94-98
41	41	40,5-41,5	59 63	100	98-102
42	42	41,5-42,5	59 64	104	102-106
43	43	42,5-43,5	60 64	108	106-110

44	44	43,5-44,5	60 64	112	110-114
45	45	44,5-45,5	60 65	116	114-118
Эмэгтэй					
34	34	33,5-34,5	57 59	80	78-82
35	35	34,5-35,5	57 59	84	82-86
36	36	35,5-36,5	58 60	88	86-90
37	37	36,5-37,5	58 60	92	90-94
38	38	37,5-38,5	59 61	96	94-98
39	39	38,5-39,5	59 61	100	98-102
40	40	39,5-40,5	59 61	104	102-106
41	41	40,5-41,5	59 61	108	106-110

6.3-р хүснэгт. Лаборант, тогоочийн цамц ба өмдний хэмжээ

Хувцасны өмсгөл хэмжээ ба биеийн хэмжээ (Эрэгтэй)				
Хувцасны өмсгөл хэмжээ	Хэв шинжит галбирын чац, см	Чацын хэмжээний хэлбэлзэл, см (±3)	Цээжний бүслүүр хэмжээний хэлбэлзэл, см (±2)	Бэлхүүсний бүслүүр хэмжээний хэлбэлзэл, см (±2)
44-46	158	155-160,9	88-92 86-94	78-82 76-84
48-50	164	161-166,9	96-100 94-102	86-90 84-92
52-54	170	167-172,9	104-108 102-110	94-98 92-100
56-58	176	173-178,9	112-116 110-118	102-106 100-108
60-62	182	179-190,9	120-124 118-126	110-114 108-116
Хувцасны өмсгөл хэмжээ ба биеийн хэмжээ (Эмэгтэй)				
40-42	152	149-154,9	80-84 78-86	88-92 86-94
44-46	158	155-160,9	88-92 86-94	96-100 94-102
48-50	164	161-166,7	96-100 94-102	104-108 102-110
52-54	170	167-172,9	104-108 102-110	112-116 110-118
56-58	176	173-178,9	**112-116** 110-117,9	**120-124** 118-126

6.4-р хүснэгт. Зохион байгуулагчийн даашинз, пиджак (хагас бариу)

Хувцасны өмсгөл хэмжээ	Хэв шинжит галбирын чац, см	Чацын хэмжээний хэлбэлзэл, см (±3)	Цээжний бүслүүр хэмжээний хэлбэлзэл, см (±2)	Бэлхүүсний бүслүүр хэмжээний хэлбэлзэл, см (±2)
44	152	149-154,9	(88) 86-90	(96) 94-98
46	158	155-160,9	(92) 90-94	(100) 98-102
48	164	161-166,7	(96) 94-98	(104) 102-106
50	164	161-166,7	(100) 98-102	(108) 106-110
52	170	167-172,9	(104) 102-106	(112) 110-114
54	176	173-178,9	(108) 106-110	(116) 114-118

Өвлийн дулаан цамц, сүлжмэл даавуун цамц (богино ханцуйтай захтай цамц) 6.5-р хүснэгтэд үзүүлсэн өмсгөл хэмжээтэйгээр үйлдвэрлэнэ.

6.5-р хүснэгт. Дулаан флис цамц, сүлжмэл даавуун цамцны өмсгөл хэмжээ ба биеийн хэмжээ

Цамцны өмсгөл хэмжээ		Цээжний бүслүүр, см	Биеийн өндөр, см (хэлбэлзэл 6 см)	Биеийн өндрийн хэлбэлзэл, см
Стандарт	Олон улсын			
Хувцасны өмсгөл хэмжээ ба биеийн хэмжээ (Эрэгтэй)				
44-48	**S**	84-92 96-104	**164**	**161-167**
48-50	**M**	84-92 96-104	**170**	**167-173**
50-52	**L**	84-92 96-104	**176**	**173-179**
52-54	**XL**	88-100 104-116	**182**	**179-185**
54-56	**2XL**	92-100 104-116	**188**	**185-191**
Хувцасны өмсгөл хэмжээ ба биеийн хэмжээ (Эрэгтэй)				
40-42	**XS**	80-84 78-86	**152**	**149-155**
44-46	**S**	88-92 86-94	**158**	**155-161**
48-50	**M**	96-100 94-102	**164**	**161-167**
52-54	**L**	104-108 102-110	**170**	**167-173**
56-58	**XL**	112-116 110-118	**176**	**173-179**

Дээр дурьдсан өмсгөл хэмжээнээс их эсвэл бага үед хэрэглэгчийн биеийн хэмжээний онцлогт тохируулан захиалгаар үйлдвэрлэнэ.

Гутлын өмсгөл хэмжээг хүйсээс хамааруулан 6.6-р хүснэгтэд үзүүлэв.

6.5-р хүснэгт. Гутлын өмсгөл хэмжээ

Гутлын өмсгөл хэмжээ	Хөлийн тавхайн урт, см	
	Эрэгтэй	Эмэгтэй
35	-	22,8
36	-	23,5
37	-	23,8
38	24,1	24,5
39	24,4	25,1
40	24,8	25,4
41	25,7	26,0
42	26,0	-
43	27,0	-
44	27,3	-
45	28,3	-
46	28,6	-

6.2.1 Нийтлэг шаардлагууд

6.2.1.1 Хамгаалах шаардлага

a) Хувцасны хийц нь үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлс хувцасны дотор тал руу үсрэх, урсах, нэвтрэх, нэвчихээс дээд зэргээр хамгаалсан байна.

b) Хувцасны хамгаалах чадварыг нэмэгдүүлэхийн тулд үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлсээс хамгаалах шинж чанартай материалаар давхарлагууд хийж өгнө. Хамгаалах давхарлагуудын байрлал, хэлбэр нь хөдөлмөрийн нөхцөлөөс хамаарч, үйлдвэрлэлийн аюултай хортой хүчин зүйлийн шинж чанараар тодорхойлогдоно.

c) Хувцасны гадаргуу нь үйлдвэрлэлийн хортой, аюултай бодис, бохирдлын үлдэгдэл тогтохоргүй толигор байна.

d) Хувцасны гадаргууд үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжтэй ороцолдох, дэгээдэгдэх бүч гэх мэт сул үзүүр байхгүй байна.

e) Хувцасны өнгө нь үйлдвэрлэлийн байрны болон тухайн ажлын байрны онцлог, интерьер, гэрэлтүүлэгт зохицсон, машин тоног төхөөрөмжөөс ялгарч харагдах өнгөтэй байна. Хувцас нь алсаас болон гэрэл багатай, харанхуй газарт ажилтны байгаа газрыг мэдээлдэг дохиоллын элементтэй байна. Өвлийн флис цамцны цацруулагчийн өргөн 2,5 см, бусад бүх хувцсанд цацруулагчийн өргөн 5 см байна.

f) Аюул тохиолдсон үед шаардлагатай бол тайлахад хялбар байна.

6.2.1.2 Эргономикийн шаардлага

Өдөр тутам өмсөх ажлын хувцасны загварыг дараах шаардлагуудад нийцүүлэн зохион бүтээнэ. Үүнд:

a) Хувцас нь өмсөх цаг агаарын нөхцөл, улиралд тохирсон байна (зун, өвөл).

b) Хувцас нь зохих хамгаалалтын зэрэгцээ хэрэглэгчийн тав тухтай байдлыг хангасан байна.

c) Хувцас нь хүний эрүүл мэндэд хортой болон тааламжгүй нөлөө үзүүлэхээргүй хийц, материалтай байна.

d) Хувцасны хүний биед хүрэлцэх хэсгүүд арьсанд аливаа цочроо, шархлаа үүсгэх хурц ирмэггүй байна.

e) Хувцасны хийц нь тухайн мэргэжлийн онцлог, хөдөлмөрийн нөхцөл, биеийн хөдөлгөөнд тохирсон, биед эвтэй, ажлын явцад чөлөөтэй хөдлөх боломжийг хангасан, товчлоос нь өмсөж тайлахад хялбар байна.

f) Хувцасны зарим бүрдэл хэсгүүдийн хэмжээг хувь хүний биеийн морфологийн онцлогт тохируулан өөрчилж болохуйц хийцтэй байж болно.

g) Хувцас нь эрүүл ахуйн шаардлага хангасан, чийг шингээлт, агаар нэвтрүүлэлт сайтай, өвлийн хувцас нь хүйтнээс найдвартай хамгаалах хийцтэй байна.

h) Хувцасны хийцэд хувцасны дорхи давхаргын бичил цаг уурын хэвийн байдлыг дэмжих элементүүд оруулж болно: хөлс ихээр ялгардаг хэсгүүдэд салхивчны нүх, онгорхой гэх мэт.

i) Цээжний, бүсэлхийн, өгзөгний бүслүүр дээрх чөлөөт хөдөлгөөний сулын тавилтын хэмжээ нь амьсгалах, цусны эргэлт, хувцасны дорхи давхаргын агаарын хөдөлгөөн, биеийн хөдөлгөөний чөлөөт байдлыг хангасан байна.

j) Хувцасны жин нь ажилтны бие организмд сөрөг нөлөө үзүүлэхээргүй байна.

k) Хөдөлмөрийн багаж хэрэгсэл хийх халаас болон товчлоос, бусад шаардлагатай элементүүд нь оновчтой хэмжээ, байрлал, хийцтэй байна.

6.2.1.3 Эдэлгээний шаардлагууд

a) Хувцас нь бөх бат, нормт хугацааны туршид хамгаалах чадвараа хадгалах, эдэлгээнд найдвартай (хэлбэрээ хадгалалт, элэгдэлт тэсвэрлэлт сайтай), засварлах боломжтой, шаардлагатай тооны угаалга, индүүдлэгийг тэсвэрлэх чадвартай байна.

b) Ашиглалтын явцад хувцасны материал, оёсон оёдол нь урагдахгүй, элэгдэл болон үйлдвэрлэлийн төрөл бүрийн хүчин зүйлийн нөлөөллийг тэсвэрлэх чадвартай байна.

6.2.1.4 Гоо зүйн шаардлага

a) Хувцасны загвар дизайн, өнгөний шийдлүүдийг хэрэглэгчтэй тохирсны үндсэн дээр өдөр тутам өмсөх ажлын хувцасны орчин үеийн загварын чиг хандлагад болон хэрэглэгчийн таашаалд нийцүүлэн, хувцасны дизайны зарчмуудыг баримтлан боловсруулсан байна.

b) Өдөр тутам өмсөх ажлын хувцасны загваруудын гадаад байдал нь Ус сувгийн удирдах газрын даргын тушаалаар батлагдсан зургийн цомогт үзүүлсэн техникийн зургуудтай тохирч байна.

c) Хувцасны боловсруулалт, шошго, лого эмблем нь зохих шаардлага хангасан, гадаад үзэмж чанарын шаардлага хангасан байна (6.7-р хүснэгт).

d) Логоны өнгийг Ус сувгийн удирдах газрын brandbook-д заасан кодын дагуу гаргана.

e) Логоны хэмжээ, үсгийн фонт бүх төрлийн ажлын хувцсанд ижил байна.

f) Логог Ус сувгийн удирдах газрын brandbook-д заасны дагуу 6.1-р зурагт харуулсан цэнхэр өнгөөр хатгамалын машинаар оёно.

g) Үсгийн фонд Arial байна.

h) Байгууллагын лого, таних тэмдгийг өвлийн болон зуны ажлын хувцас дээр компьютер хатгамал (утас нь - хатгамлын зориулалттай торгон), эсвэл хэвлэлийн орчин үеийн аргаар (digital textile printing, heat transfer гэх мэт) хийсэн байна.

6.7-р хүснэгт. Лого, таних тэмдгийн байрлал, өнгө, хэмжээ

Хэмжээ, мм	Логоны гадна тойргийн хэмжээ 6,6 см байна.
Логоны зураг	 6.1-р зураг
Байрлал	Зүүн ханцуйны мөрний оёдлоос доош 15 см зайд ханцуйны голд байрлана. Хантаазны зүүн энгэрт мөрний оёдлоос 12,5см зайд байрлана.
Логоны суурь өнгө	Цагаан суурин дээр цэнхэр өнгөөр хатгаж оёно.
Ажлын хувцасны арын бүрдэл хэсэг дээрх бичилт	УСУГ бичиглэлийг Arial фондоор, үсгийн өргөн Bold, үсгийн өндөр 5 см, уртын хэмжээг 15 см-т багтаан өвлийн хүрэмний арын бүрдэл хэсэг дээр хатгамлаар оёно. Хөх өнгөтэй бүрдэл хэсэг дээр цэнхэр өнгөөр, саарал өнгөтэй бүрдэл хэсэг дээр хар хөх өнгөөр тус тус бичнэ.
Ажлын хувцасны энгэрийн бүрдэл хэсэг дээрх бичилт	Зуны хүрэм, цамцны зүүн энгэр дээр УСУГ бичиглэлийг бичиглэлийг Arial фондоор, үсгийн өргөн Bold, үсгийн өндөр 2 см, уртын хэмжээг 10 см-т багтаан хатгамлаар оёно. Хөх өнгөтэй бүрдэл хэсэг дээр цэнхэр өнгөөр, саарал өнгөтэй бүрдэл хэсэг дээр хар хөх өнгөөр тус тус бичнэ.

i) Ажилтнуудын ажлын хувцас нь гүн болон цэнхэр өнгийг хослуулсан байна.

Хувцасны нэр төрлөөс хамаарсан өнгөний кодыг 6.8-р хүснэгтэд үзүүлэв.

6.8-р хүснэгт. Ажлын хувцасны өнгөний код

№	Pantone систем дэх өнгөний код		Тайлбар
1	Гүн хөх (Astral aura)	PANTONE 19-3830 TPX	
2	Саарал (Ice Flow)	PANTONE 13-4404 TPX	
3	Цайвар цэнхэр (Vista Blue)	PANTONE 15-3930 TPX	
4	Цэнхэр (Dazzling blue)	PANTONE 18-3949 TPX	
5	Неон шар (Sulphur Spring)	PANTONE 13-0650 TPX	
6	Цагаан (Bright White)	PANTONE 11-0601 TPX	

6.2.1.5 Хөдөлмөрийн аюулгүй байдлын шаардлага

a) Өдөр тутам өмсөх ажлын хувцас нь ашиглалтын явцад аюултай, хор хөнөөлтэй хүчин зүйл, ослын шалтгаан болохгүй байна.

b) Өдөр тутам өмсөх ажлын хувцас, дагалдах хэрэгсэл үйлдвэрлэх материал нь ариун цэвэр, эрүүл ахуйн үзүүлэлтүүдийн тогтоосон стандартад нийцсэн байна.

c) Хувцасны материал нь хүний биед хортой нөлөө үзүүлдэг хортой хольц агуулаагүй байна. Энэхүү шаардлагыг ажлын хувцас үйлдвэрлэхэд ашигласан материалын аюулгүй талаарх шинжилгээний хуудсаар баталгаажуулна.

d) Өдөр тутам өмсөх ажлын хувцсыг дахин боловсруулах арга нь байгаль орчинд хор хөнөөл учруулахгүй байна.

e) Гэрэл ойлгогч цацруулагч материалаар тусгай зориулалтын хувцсанд ашигладаг дохионы элементүүд нь тэдгээрт тавих шаардлагад нийцнэ.

6.2.2 Бүтээгдэхүүнд ашиглах материалд тавих шаардлагууд

a) Өдөр тутам өмсөх ажлын хувцсанд ашигласан материал нь тухайн зориулалтын хувцасны хамгаалах шинж чанарыг хангах үзүүлэлтүүдтэй байна.

b) Мөн хүний эрүүл мэндэд хортой формальдегид, хүнд металл, фенол, хориглосон будаг, харшил өгдөг будаг агуулаагүй, таагүй үнэргүй, хортой бодис ууршуулдаггүй, pH хэвийн байх нэмэлт шаардлага хангасан байна.

c) Ажлын хувцсанд дахин боловсруулсан даавууг ашиглахгүй.

6. 2.2.1 Хувцасны гадар материалд тавих шаардлага

Өдөр тутам өмсөх ажлын хувцсыг бэлтгэхэд ашиглах гадрын даавуу нь төрөл бүрийн бүрхүүлийн үүрэг гүйцэтгэсэн боловсруулалттай байж болно: ус, тоос үл нэвтрүүлэх г.м.

Хувцасны гадрын материал нь 6.9, 6.10-р хүснэгтэд заасан шаардлагуудыг хангасан байна.

6.9-р хүснэгт. Өдөр тутам өмсөх ажлын хувцасны гадар материалын шинж чанарын үзүүлэлт (ИТА, Ажилчид)

№	Үзүүлэлтийн нэр	Хэмжих нэгж	Үзүүлэлтүүд		
			Өвлийн хүрэм, өмд, салдаг хантаазтай		Зуны хүрэм, өмд, комбинезон
			ИТА болон Цэвэрлэх байгууламж	Бусад нөхцөл	
1	Ширхэгтийн бүрэлдэхүүн, ихгүй	%	100 % полиэстер	65 % полиэстер	60 % хөвөн
2	Гадаргуугийн нягт, багагүй	г/м^2	180	235	210
3	Зузаан, ихгүй	мм	0,4	0,6	0,6
4	Бүрзийлт	балл	5	4	
	Будгийн тогтвор, -угаалтанд -нарны гэрэлд	балл	5 5	4 4	3-4 4-5
4	Тасралтын даац, -суурь утасны дагуу -хөндлөн утасны дагуу	Н	780-850 650-780	450-550 380-440	1000-1200 650-800
5	Нэхээсний нягт -суурь утасны дагуу -хөндлөн утасны дагуу	тоогоор	100-110 90-100	231-240 180-186	108-120 58-70
6	Агаар нэвтрүүлэлт, багагүй	дм^3 /м^2 с	40	40	100
7	5 удаагийн угаалтын дараах агшилт	%	-	±3	±3
8	Элэгдэлт тэсвэрлэлт, багагүй:	20 000 эргэлт	4	4	4
9	Формальдегидын хэмжээ, ихгүй	мкг/г,	150	150	7

Өвлийн өдөр тутам өмсөх ажлын хувцасны гадар материал нь гадны механик үйлчлэлд тэсвэртэй, гаднаас ус чийг нэвтрүүлэхгүй, хөлддөггүй, цан цохидоггүй байна.

Салхины хамгаалалтын давхаргын уур нэвтрүүлэлт 4.0 мг/(см*цаг)-аас багагүй байна.

6.10-р хүснэгт. Өдөр тутам өмсөх ажлын хувцасны материалын шинж чанарын үзүүлэлтүүд

Үзүүлэлтийн нэр	Хэмжих нэгж	Үзүүлэлт		
		Ус түгээгч, үйлчлэгчийн өмд, бүх төрлийн хантаазууд	ИТА, хамгаалагчийн цамц, лабораторийн цамц, өмд	Богино ханцуйтай захтай цамц
Байгалийн гаралтай ширхэгтийн агууламж, багагүй	%	35% хөвөн	60±3 % (хөвөн)	50 % хөвөн
Хиймэл ширхэгтийн агууламж, Ихгүй	%	62 % Полиэстер, 3 % спандекс	37+3 (Полиэстер+ спандекс)	50 % Полиэстер
Гадаргуугийн нягт, багагүй	г/м^2	170	210	180
Агаар нэвтрүүлэлт, багагүй	дм^3 /м^2 с	150	40	150
Чийг шингээлт, багагүй	%	25	30	25
Тасралтын даац, багагүй: -суурь утасны дагуу -хөндлөн утасны дагуу	Н	490 255	1200 800	490 255
Элэгдэлт тэсвэрлэлт, багагүй:	эргэлт	9000	20000	9000
5 удаагийн угаалтын дараах агшилт, ихгүй: - суурь утасны дагуу - хөндлөн утасны дагуу	%	±2,0	±2,0	±2,0
Будгийн тогтвор - угаалтанд -нарны гэрэлд	балл	3-4	4-5	3-4
Үнэр шингээлт, ихгүй	балл			

6. 2.2.2 Дотрын материалд тавих шаардлага

Хувцасны дотрын зориулалтаар ашиглах материалд 6.11-р хүснэгтэд заасан шаардлагуудыг тавина.

6.11-р хүснэгт. Дотрын материалын шинж чанарын үзүүлэлт

№	Үзүүлэлтийн нэр	Хэмжих нэгж	Үзүүлэлтийн утга	
			Гялгар /өвлийн хүрэмний ханцуй /	Даавуун /өвлийн хүрэмний дулаалга/
1	Ширхэгтийн бүрэлдэхүүн, багагүй	%	Хиймэл ширхэгт 80-100	Хөвөн ширхэгт 80
2	Гадаргуугийн нягт, багагүй	г/м^2	110	150
3	Тасралтын даац, багагүй: -суурь утасны дагуу -хөндлөн утасны дагуу	Н	200 150	250 200
4	Элэгдэлт тэсвэрлэлт, багагүй	эргэлт	6000	6000
5	Чийг шингээх чадвар, багагүй	%	7	7
6	Агаар нэвтрүүлэлт, багагүй	дм^3/м^2 с	100	100

7	5 удаагийн угаалтын дараах агшилт, ихгүй -суурь утасны дагуу -хөндлөн утасны дагуу	%	-3.5 ±2.0	±2,0 ±2,0
8	Будгийн тогтвор, дээш -угаалтанд -нарны гэрэлд	балл	4	4

6. 2.2.3 Хувцасны дулаалгын материалд тавих шаардлага

Хувцасны дулаалганд зузаан болон давхаргын тоогоор шаардлагатай дулаан хадгалах чадварыг хангаж чадах, шаталтыг дэмждэггүй ямар ч төрлийн дулаалгын материал ашиглаж болно. Энд нэхээсгүй дулаалгууд (тэмээний ноос, синтефон, тинсулейт зэрэг төрөл бүрийн ширхэгтээр үйлдвэрлэгдсэн), хөвөн, өд сөдөн дулаалга (дүүргэгч) г.м багтана.

Дулаалгын материал нь 6.12-р хүснэгтэд заасан шаардлагыг хангасан байна.

6.12-р хүснэгт. Ширмэл дулаалгын материалд тавих шаардлага

№	Үзүүлэлтийн нэр	Үзүүлэлтийн утга
1	Ширхэгтийн бүрэлдэхүүн	35 % полиэстер, 65 % полипропилен бүхэл ширхэгт, эсвэл 100 % полиэстер
2	Нягт, багагүй	300 г/ м^2 (синтефон)+ 150 г/ м^2 (ширмэл өнгө)
3	Хийцийн онцлог	Дотрын материалтай ширсэн
4	Гадрын болон дотрын материалыг дулаалгын ширхэгтийн нэвчин гарах	150 см^2 талбайд хоёроос ихгүй ширхэгт
5	Чийг шингээх чадвар, %, багагүй	3

Түгээмэл хэрэглэгдэж буй хиймэл ширхэгтэн дулаалгын материалын шинж чанарын үзүүлэлтүүд (6.13-р хүснэгт) тохирсон байна.

6.12-р хүснэгт. Хиймэл ширхэгтэн дулаалгын материалын шинж чанарын үзүүлэлт

№	Үзүүлэлтийн нэр		Үзүүлэлтийн утга
1	Гадаргуун нягт, г/м^2		80-200
2	Зузаан, мм, багагүй		30
3	Нягт, Oz/y^2 / г/ м^2, багагүй	Ар, энгэрт	10/340
		Ханцуй, өмдний бүрдэл хэсэгт	8/272
		Халаасны таг, цахилгааны даралт, зах бусад хэсэгт	2/65
4	Жингийн жигд бус байдал, %		±10
5	Агшилт, % -суурь утасны дагуу -хөндлөн утасны дагуу		±2,5

Өвлийн дулаан цамц нь материалын төрлөөс хамаарч 6.13, гагнуурчны хувцасны илгэн материалын шинж чанарын үзүүлэлтүүд 6.14-р хүснэгтийн чанарын үзүүлэлтэд тохирсон байна.

6.13-р хүснэгт. Өвлийн дулаан цамцны флис материалын шинж чанарын үзүүлэлт

№	Үзүүлэлтийн нэр	Төрөл	
		Нэг талдаа үстэй	Хоёр талдаа үстэй
1	Ширхэгтийн бүрэлдэхүүн,	100 % Полиэстер	
2	Зузаан, мм	1,3	2,5
3	Тасралтын даац, Н, багагүй	200	300
4	Элэгдэлт тэсвэрлэлт, эргэлт, багагүй:	5000	
5	Дулааны эсэргүүцэл, м2 °С/Вт, багагүй	0,18	0,22
6	Агаар нэвтрүүлэлт, дм3/м2-с, багагүй	150	100
	Будгийн тогтвор, оноо, багагүй: - угаалга - хөлс - хуурай үрэлтэнд - нойтон үрэлтэнд	 4 4 4 4	

6.14-р хүснэгт. Гагнуурчны хувцасны илгэн материалын шинж чанарын үзүүлэлт

№	Үзүүлэлтийн нэр	Үзүүлэлтийн утга
1	Зузаан,мм	0,7-1,1
2	Чийгийн хэмжээ, % ихгүй	16,0
3	Үнсний агууламж, % ихгүй	8,0
4	Органик уусгагчаар гаргаж авсан бодисын массын хувь, % багагүй	3,0

6. 2.2.5 Туслах материалд тавих шаардлага

a) Туслах материал болох цахилгаан товч, товч, зангуу нь хүйтэн нөхцөл, химиц цэвэрлэгээ, индүүдлэг даах чадвартай байна.

b) Хувцасны туслах тоноглол, оёдлын утасны өнгө нь гадар материалын өнгөтэй зохицсон байна.

6.2.3 Бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд тавих шаардлагууд

a) Хувцсыг энэхүү стандартад дурьдсан шаардлагуудад нийцүүлэн батлагдсан эх загвараар техникийн баримт бичигт заасны дагуу үйлдвэрлэнэ.

b) Хувцсанд хатгац, оёдол хийхэд тавих шаардлага:

- Хувцасны хатгац, оёдлын төрөл MNS ISO 4916, MNS ISO 4915 стандартад нийцсэн байна.
- Хувцасны бүх оёдол 1,0 см-т 3-аас 3,5 ширхэг хатгацтай байх ба ил оёдол нь тэгш, алгасаагүй, шигээгүй, тунараагүй, муруйгүй байна.
- Хувцасны нэгтгэх оёдлуудын тасралтын ачаалал 250 Н-аас багагүй байна.
- Хувцасны суга, өмдний суудлын оёдол, халаас, мөрний оёдол гэх мэт ачаалалд их өртдөг зангилаа хэсгүүдийн бат бөх байдлыг хангахын тулд нэгтгэж оёхоос гадна хос ил оёдол хийнэ.
- Хос оёдол хоорондын зай загвараас хамаарах бөгөөд оёдлын бүх уртын туршид ижил зайд зэрэгцээ байрлана.
- Хувцсанд ашиглах үндсэн болон туслах материалын өнгөтэй зохицсон өнгийн, бөх утсаар оёно.
- Гагнуурчны хувцасны оёдлыг галд тэсвэртэй утсаар 1,0 см-т 3-аас 3,5 ширхэг хатгацтай байхаар оёно.

c) Оёдол бүрийн төгсгөлд зайлшгүй бөхөлгөө хийх ба түүнд тавих шаардлага нь:

- Ердийн хатгац (MNS ISO 4915:2012) бүхий оёдлын төгсгөлд буцах чиглэлээр 0,7 см-ээс 1,0 см урттай бөхөлгөө хийнэ.
- Гинжин хатгац бүхий оёдлын бөхөлгөөг 1,0 см-д ноогдох хатгацын тоог 10 ширхэг хүртэл нэмэгдүүлэх байдлаар эсвэл оёдлын утсыг 0,5 см-ээс 0,7 см урттайгаар үлдээж хийнэ.
- Битүү оёдлын эхлэл төгсгөлийн бөхөлгөөг оёдлын мөрөн дээр 1,0 см-ээс 2,0 см урттайгаар давхарлаж хийнэ.
- Бүх хувцасны халаасны таг, хагалбар болон оёдолд орсон ташуу халаасны эхлэл, төгсгөл, ил халаасны амсар, далд товчлоос, оноо, хагалбар, цахилгаантай болон товчтой өмдний халаа, бүсний сойлт, саалт, түдүүлд тусгай зориулалтын машинаар бөхөлгөө хийнэ.
- Товч, цахилгаан товч хадах, товчны нүх гаргахад тавих шаардлага:
- Товчны нүхний уртын хэмжээ уг бүтээгдэхүүнд хадагдах товчны диаметрээс 0,2 см-ээс 0,5 см илүү байна.
- Товч хадах, товчны нүх гаргахдаа хоёроос доошгүй давхарласан материал дээр хийж гүйцэтгэнэ.
- Товчны нүхийг заавал тусгай зориулалтын машинаар гаргаж, цоолсон байх ба төгсгөлийг бөхөлсөн байна.
- Товчийг товчны нүхтэй ижил өнгийн утсаар оёно.
- Товчлоосны зориулалттай товчийг зориулалтын машинаар оёно.
- Товч нь ажлын хувцасны өнгө дагуу байх.
    - Машинаар хадах үед: товчний нүх болгоныг 12-оос доошгүй хатгацаар оёно.
- Бүтээгдэхүүний ил харагдах бүх зах ирмэгүүдийг боловсруулсан (хэрэх, эмжих г.м) байна.

6.2.4 Хувцасны шошгонд тавих шаардлага

a) Хувцас бүр үйлдвэрлэгчийн нэр, үйлдвэрлэсэн улс, тухайн хувцасны өмсгөл хэмжээ, өмсөх хүний биеийн хэмжээ (биеийн өндөр, цээжний тойрог), материалын ширхэгтийн холио, ашиглалтын заавар (ISO 3758) мэдээлэл бүхий шошготой байна.

b) Шошго нь сайн харагдах, элэгдэл багатай газар байрлах ба уншигдах боломжтой, гаргацтай байна.

ЖИЧ: гадуур хувцасны шошгыг арын дотрын голд хоолойн ухлаадасны шугамнаас доош, өмсгөл хэмжээ, өмсөх хүний биеийн хэмжээ, материалын ширхэгтийн холио, угаалга ашиглалтын заавар мэдээлэл бүхий шошгыг дотрын зүүн талын хажуугийн оёдолд хавчуулж оёхыг; дан хувцасны хувьд дотрын халаасны ирмэгээс доош, өмдний хувьд ар бүсний залгаас оёдолд хавчуулж оёхыг зөвлөж байна.

c) Шошго нь тухайн хувцасны заагдсан эдэлгээний хугацаанд угаалга, цэвэрлэгээг (угаалга, цэвэрлэгээний тоонд тохирох) тэсвэрлэхээр бат бөх байна.

d) Шошго нь хүний арьсыг нухаж холгохгүй, харшил өгөхгүй материалаар хийгдсэн байна.

e) Шошго, зурган тэмдэглэгээ (пиктограмм) нь тоон болон тусгай мэдээллийг хурдан уншиж, зөв ойлгох боломж бүхий хэмжээтэй байна.

ЖИЧ: 2 мм-ээс ихгүй хэмжээтэй цифр, хүрээтэйгээ 10 мм-ээс ихгүй хэмжээтэй зурган тэмдэглэгээг (цагаан дээр хараар бичсэн) хийж ашиглахыг зөвлөж байна.

f) Ашиглалтын заавар дараах агуулгатай байна. Үүнд:
- Шаардлагатай тохиолдолд өмсөж тайлах заавар

- Ашиглалтанд тавих хязгаарлалт (өмсөх нормт хугацаа, ашиглалтын дараа устгах заавар г.м)
- Хадгалах, арчлах заавар
- Хувцасны материалын онцлогт тохирсон цэвэрлэгээний заавар (угаах горим, химийн цэвэрлэгээний бодис, индүүдэх температурын хязгаарлалт г.м)
- Нэр бичих шошго
- Угаалгын горим

6.2.5 Хувцасны сав баглаа боодолд тавих шаардлага

a) Хувцас тус бүрийг (хос бол иж бүрдүүлж) тусгай зориулалтын гялгар уутанд савлан, хэд хэдээр нь багцалж хайрцаглана.

b) Үйлдвэрлэгч барааны дагалдах хуудсыг хоёр хувь бичиж, нэг хувийг хайрцагны дотор талд хийж, хоёр дахь хувийг хайрцагны гадна талд наана. Дагалдах хуудсанд бүтээгдэхүүний нэр төрөл, тоо ширхэг, үйлдвэрлэгчийн нэр хаяг, огноог бичсэн байна.

c) Хайрцагны хажуу талд ус, чийгээс хамгаалахыг анхааруулсан таних тэмдгийг тод өнгөөр тэмдэглэсэн байна.

ТӨГСӨВ.

А ХАВСРАЛТ
(норматив)

Хувцасны өмсгөл хэмжээ тодорхойлоход шаардлагатай биеийн үндсэн хэмжээсүүд



А.1 дүгээр зураг

УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР

“УСУГ”-ЫН АЖИЛТНЫ АЖЛЫН ХУВЦАСНЫ ЗАГВАР

УЛААНБААТАР ХОТ
2025 он

ИТА-НЫ ӨВЛИЙН ХҮРЭМ

ӨМСӨХ ЗОРИУЛАЛТ:
ИТА өвлийн улиралд өдөр тутам өмсөх зориулалттай хүрэм.
Өвлийн өмд, гуталтай хослуулан өмсөнө.

ӨНГӨНИЙ КОД:

Гүн хөх: PANTONE 19-3830 TPX Astral Aura
Цэнхэр: PANTONE 18-3949 TPX Dazzling Blue

ИТА-НЫ ӨВЛИЙН ӨМД

ӨМСӨХ ЗОРИУЛАЛТ:
ИТА өвлийн улиралд өдөр тутам өмсөх зориулалттай өмд. Өвлийн хүрэм, гуталтай хослуулан өмсөнө.



ӨНГӨНИЙ КОД:

Гүн хөх: PANTONE 19-3830 TPX Astral Aura
Цэнхэр: PANTONE 18-3949 TPX Dazzling Blue

ИТА-НЫ ӨВЛИЙН ХҮРЭМНИЙ САЛДАГ ХАНТААЗ

ӨМСӨХ ЗОРИУЛАЛТ:
ИТА-ны өвлийн хүрэмний салдаг хантааз. Хүрэмнээс салгаж өмсөх зориулалттай.



ӨНГӨНИЙ КОД:

Гүн хөх: PANTONE 19-3830 TPX Astral Aura
Цэнхэр: PANTONE 18-3949 TPX Dazzling Blue

ИТА-НЫ ХАНТААЗ

ӨМСӨХ ЗОРИУЛАЛТ:
ИТА өдөр тутам ажлын хувцасны гадуур өмсөх зориулалттай хантааз.



ӨНГӨНИЙ КОД:
Гүн хөх: PANTONE 19-3830 TPX Astral Aura
Цэнхэр: PANTONE 18-3949 TPX Dazzling Blue
Неон шар: PANTONE 13-0650 TPX Sulphur Spring

ИТА-НЫ ЗУНЫ ХҮРЭМ

ӨМСӨХ ЗОРИУЛАЛТ:
ИТА зуны улиралд өдөр тутам өмсөх зориулалттай хүрэм.

ӨНГӨНИЙ КОД:

Саарал: PANTONE 13-4404 TPX Ice Flow
Цайвар цэнхэр: PANTONE 15-3930 TPX Vista Blue

ИТА-НЫ ЗУНЫ ӨМД

ӨМСӨХ ЗОРИУЛАЛТ:
ИТА зуны улиралд өдөр тутам өмсөх өмд.



ӨНГӨНИЙ КОД:

Гүн хөх: PANTONE 19-3830 TPX Astral Aura

ИТА-НЫ НИМГЭН ЦАМЦ

ӨМСӨХ ЗОРИУЛАЛТ:
Зуны улиралд өдөр тутам өмсөх зориулалттай цамц

ӨНГӨНИЙ КОД:

Саарал: PANTONE 13-4404 TPX Ice Flow
Цайвар цэнхэр: PANTONE 15-3930 TPX Vista Blue

АЖИЛЧДЫН ЗУНЫ ХҮРЭМ

ӨМСӨХ ЗОРИУЛАЛТ:
Ажилчид зуны улиралд өдөр тутам өмсөх зориулалттай ажлын хүрэм.
Зуны өмд, ажлын гуталтай хослуулан өмсөнө.



ӨНГӨНИЙ КОД:

Гүн хөх: PANTONE 19-3830 TPX Astral Aura
Цэнхэр: PANTONE 18-3949 TPX Dazzling Blue

АЖИЛЧДЫН ЗУНЫ ӨМД

ӨМСӨХ ЗОРИУЛАЛТ:
Ажилчид зуны улиралд өдөр тутам өмсөх зориулалттай ажлын өмд.
Зуны хүрэм, ажлын гуталтай хослуулан өмсөнө.

ӨНГӨНИЙ КОД:

Гүн хөх: PANTONE 19-3830 TPX Astral Aura
Цэнхэр: PANTONE 18-3949 TPX Dazzling Blue

АЖИЛЧДЫН ӨВЛИЙН ХҮРЭМ

ӨМСӨХ ЗОРИУЛАЛТ:
Ажилчид өвлийн улиралд өдөр тутам өмсөх зориулалттай, салдаг дотортой ажлын хүрэм. Өвлийн өмд, ажлын гуталтай хослуулан өмсөнө.

ӨНГӨНИЙ КОД:

Гүн хөх: PANTONE 19-3830 TPX Astral Aura
Цэнхэр: PANTONE 18-3949 TPX Dazzling Blue

АЖИЛЧДЫН ӨВЛИЙН ӨМД

ӨМСӨХ ЗОРИУЛАЛТ:
Өвлийн улиралд өдөр тутам өмсөх зориулалттай ажлын өмд.
Өвлийн хүрэм, ажлын гуталтай хослуулан өмсөнө.



ӨНГӨНИЙ КОД:

Гүн хөх: PANTONE 19-3830 TPX Astral Aura
Цэнхэр: PANTONE 18-3949 TPX Dazzling Blue

АЖИЛЧДЫН ӨВЛИЙН ХҮРЭМНИЙ САЛДАГ ХАНТААЗ

ӨМСӨХ ЗОРИУЛАЛТ:
Ажилчдын өвлийн хүрэмний дотор талаас салдаг хантааз.



ӨНГӨНИЙ КОД:

Гүн хөх: PANTONE 19-3830 TPX Astral Aura
Цэнхэр: PANTONE 18-3949 TPX Dazzling Blue

КОМБИНЗОН

ӨМСӨХ ЗОРИУЛАЛТ:
Ажилчид зуны улиралд өмсөх зориулалттай комбинзон.
Өвдөгний хэсэгт хатуулга хийх зориулалтын ууттай.



ӨНГӨНИЙ КОД:

Гүн хөх: PANTONE 19-3830 TPX Astral Aura
Цэнхэр: PANTONE 18-3949 TPX Dazzling Blue

ГАГНУУРЫН ТУСГАЙ ХУВЦАС (ХҮРЭМ)

ӨМСӨХ ЗОРИУЛАЛТ:
Гагнуурын ажил гүйцэтгэхдээ өмсөх очинд тэсвэртэй илгэн материалын хосолгоотой хүрэм. Очинд тэсвэртэй өмдний хамт өмсөнө.

ӨНГӨНИЙ КОД:

Жинс: PANTONE 17-3922 TPX Blue Ice
Илгэ: PANTONE 19-3839 TPX Blue Ribbon

ГАГНУУРЫН ТУСГАЙ ХУВЦАС (ӨМД)

ӨМСӨХ ЗОРИУЛАЛТ:
Гагнуурын ажил гүйцэтгэхдээ өмсөх очинд тэсвэртэй илгэн материалын хосолгоотой өмд. Өвдөгний дотор талд хатуулга хийх зориулалттай ууттай.



ӨНГӨНИЙ КОД:

Жинс: PANTONE 17-3922 TPX Blue Ice
Илгэ: PANTONE 19-3839 TPX Blue Ribbon

АЖИЛЧДЫН ЦАЦРУУЛАГЧТАЙ ХАНТААЗ

ӨМСӨХ ЗОРИУЛАЛТ:
Аюулгүй ажиллагаа, харагдацыг нэмэгдүүлэх ажлын хувцасны гадуур өмсөх зориулалттай цацруулагчтай хантааз.

ӨНГӨНИЙ КОД:

Гүн хөх: PANTONE 19-3830 TPX Astral Aura
Неон шар: PANTONE 13-0650 TPX Sulphur Spring

ЖОЛООЧИЙН ХАНТААЗ

ӨМСӨХ ЗОРИУЛАЛТ:
Жолооч өдөр тутам, ажлын хувцасны гадуур өмсөх зориулалттай хантааз.



ӨНГӨНИЙ КОД:
Гүн хөх: PANTONE 19-3830 TPX Astral Aura
Цэнхэр: PANTONE 18-3949 TPX Dazzling Blue
Неон шар: PANTONE 13-0650 TPX Sulphur Spring

ЛАБОРАТОРИЙН АЖИЛТНЫ ЦАМЦ /эмэгтэй/

ӨМСӨХ ЗОРИУЛАЛТ:
Өдөр тутам өмсөх зориулалттай цамц. Өмдтэй хослуулан өмсөнө.

ӨНГӨНИЙ КОД:

Цайвар цэнхэр: PANTONE 15-3930 TPX Vista Blue

ЛАБОРАТОРИЙН АЖИЛТНЫ ӨМД /эмэгтэй/

ӨМСӨХ ЗОРИУЛАЛТ:
Өдөр тутам өмсөх зориулалттай өмд. Цамцтай хослуулан өмсөнө.

ӨНГӨНИЙ КОД:

Гүн хөх: PANTONE 19-3830 TPX Astral Aura

ЛАБОРАТОРИЙН АЖИЛТНЫ ЦАМЦ /эрэгтэй/

ӨМСӨХ ЗОРИУЛАЛТ:
Өдөр тутам өмсөх зориулалттай ажлын цамц. Өмдтэй хослуулан өмсөнө.



ӨНГӨНИЙ КОД:

Цайвар цэнхэр: PANTONE 15-3930 TPX Vista Blue

ЛАБОРАТОРИЙН АЖИЛТНЫ ӨМД /эрэгтэй/

ӨМСӨХ ЗОРИУЛАЛТ:
Өдөр тутам өмсөх зориулалттай ажлын өмд. Цамцтай хослуулан өмсөнө.

ӨНГӨНИЙ КОД:

Гүн хөх: PANTONE 19-3830 TPX Astral Aura

БОГИНО ХАНЦУЙТАЙ, ЗАХТАЙ ЦАМЦ (ПОЛО)

ӨМСӨХ ЗОРИУЛАЛТ:
Ус түгээгч, үйлчлэгчид өдөр тутам өмсөх богино ханцуйтай, захтай цамц. Өмдтэй хослуулан өмсөнө.



ӨНГӨНИЙ КОД:

Цайвар цэнхэр: PANTONE 15-3930 TPX Vista Blue

ДУЛААН ФЛИС ЦАМЦ

ӨМСӨХ ЗОРИУЛАЛТ:
Ус түгээгч, үйлчлэгчид өдөр тутам поло цамц, өмдтэй хослуулан өмсөнө.

ӨНГӨНИЙ КОД:

Цэнхэр: PANTONE 18-3949 TPX Dazzling Blue

АЖЛЫН ӨМД

ӨМСӨХ ЗОРИУЛАЛТ:
Ус түгээгч, үйлчлэгчид өдөр тутам өмсөх өмд. Өмдний бүс нь хэмжээ томруулах зориулалттай резин оруулгатай.



ӨНГӨНИЙ КОД:

Гүн хөх: PANTONE 19-3830 TPX Astral Aura

ЗОХИОН БАЙГУУЛАГЧИЙН ЖАКЕТ

ӨМСӨХ ЗОРИУЛАЛТ:
Өдөр тутам өмсөх зориулалттай жакет. Платьены гадуур өмсөнө.

ӨНГӨНИЙ КОД:

Гүн хөх: PANTONE 19-3830 TPX Astral Aura

ЗОХИОН БАЙГУУЛАГЧИЙН ПЛАТЬЕ

ӨМСӨХ ЗОРИУЛАЛТ:
Өдөр тутам өмсөх зориулалттай платье. Жакетны дотор талд өмсөнө.



ӨНГӨНИЙ КОД:

Гүн хөх: PANTONE 19-3830 TPX Astral Aura
Цайвар цэнхэр: PANTONE 15-3930 TPX Vista Blue

ТОГООЧИЙН ХУВЦАС /иж бүрдэл/

ӨМСӨХ ЗОРИУЛАЛТ:
Тогооч өдөр тутам өмсөх зориулалттай малгай, ханцуйвч, цамц, өмд, хормогчны иж бүрдэл.



ӨНГӨНИЙ КОД:

Цагаан: PANTONE 11-0601 TPX Bright White
Гүн хөх: PANTONE 19-3830 TPX Astral Aura
Цайвар цэнхэр: PANTONE 15-3930 TPX Vista Blue

ХАМГААЛАЛТЫН АЖИЛТНЫ ЦАМЦ, ӨМД

ӨМСӨХ ЗОРИУЛАЛТ:
Харуул хамгаалалтын ажилтан ажлын байран дээрээ өмсөх цамц, өмдний хослол



ӨНГӨНИЙ КОД:

Гүн хөх: PANTONE 19-3830 TPX Astral Aura
Саарал: PANTONE 13-4404 TPX Ice Flow